



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Гурванбулаг сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:**

---

Цахим хуудас:  
[www.bulgan@audit.mn](mailto:www.bulgan@audit.mn)

Булган аймаг  
2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын  
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр  
Утас:70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 70342716 Цахим хаяг:Enhtsoodolj@audit.gov.mn  
Гэрээт аудитор: П.Эрдэнэзул  
Утас:70342495 Цахим хаяг: Erdenezulp@audit.gov.mn

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	11
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	11
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал.....	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	14
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	22
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.03.24 № 130

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА А.ЭРДЭНЭБУЛГАН ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гурванбулаг сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Гурванбулаг сумын Засаг даргын нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн

006020206

тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## Аудитын тайлан

---

### 2.1. Оршил

Гурванбулаг сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга А.Эрдэнэбулган танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 18-наас 2020 оны 03 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор П.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Гурванбулаг сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/98 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБООУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Гурванбулаг сумын үйл ажиллагааны эрхэм зорилго нь нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, мэргэшсэн чадварлаг боловсон хүчний идэвхтэй үйл ажиллагаагаар төрийн үйлчилгээг иргэдэд хөрөнгө шуурхай хүргэн, байгууллага хувь хүмүүсийн үр нөлөөтэй санаачилга үйл ажиллагааг удирдан чиглүүлэх замраар сумын эдийн засгийн чадавх иргэдийнхээ амьжиргааны түвшинг дээшлүүлэн, ажиллах амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд оршино.

Сумын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББООУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Гурванбулаг сумын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ахмадын хөгжлийг дэмжих жил
- Залуучуудын хөгжлийг дэмжих
- Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил
- Хуулиа хэрэгжүүлбэ, хандлагаа өөрчилбэ
- Өвлөн суралцаж, Зөвлөн тусалъя

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомжууд Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль / шинэчилсэн найруулга/
- Төсөв баталсан Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Төсөв баталсан Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид шагнал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн мөнгөн урамшуулал олгох)
- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох)

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол Журам батлах тухай(Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох)
- Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12 -ны өдрийн 228 дугаар тушаал (Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам)
- Сангийн сайдын 2007 оны 11 дугаар сарын 30 -ны өдрийн 326 дугаар тушаал (Журам батлах тухай Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар)

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гурванбулаг сумын хэмжээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд си ти эс программ хангамжийг ашигладаг байна.

Гурванбулаг сумын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд (Дунд) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Гурванбулаг сумын 2019 оны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2894875,5 мянган төгрөгөөс тооцон 57897,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг. 57897,5 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийг дунд гэж үзсэнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гурванбулаг сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5950357,6 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	69593558.79	157605199.22	-88008640.43
Авлага	224256144	152027338	72228806
Урьдчилгаа			
Бараа материал	309938611.51	377883446.29	-67944834.78
Үндсэн хөрөнгө	498948115.55	5262841670.85	4763893555.30
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5590736429.85</b>	<b>5950357654.36</b>	<b>-359621224.51</b>
Өр төлбөр	4285601.07	508347.50	3777253.57
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5586450828.78	5949849306.86	-363398478.08
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5590736429.85</b>	<b>5950357654.36</b>	<b>-359621224.51</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдийг Булган аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд өгч зээлийг төлүүлж ажилласнаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2013-2019 онуудад үүссэн сум хөгжүүлэх сангийн хувь хүнээс авах авлага, мөн сумын “Солонго” цэцэрлэгийн хувь хүнээс авах авлага нийт 152027,3 мянган төгрөгийн авлага байна. Үүнд эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Тусгай зориулалттай аж ахуйн материал худалдан авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, бэлчээрийн суурин судалгааны төв зэрэг хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэнээс шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 460951,5 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн 54787,0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 0 мянган төгрөг, акталсан 40172,7 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь 2018 оны Засаг даргын тамгын газрын газрыг зам гүүр барилга байгууламж гэж андуурсныг 2019 оны тайланд залруулж 22084.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь эрүүл мэндийн төв өмнөх онд эмийн өглөгтэй байсан бөгөөд 2019 онд цэцэрлэг 508,3 мянган өртэй гарсан нь хүн амын

орлогын албан татварын тайланд албан хаагчдын хөнгөлөлт буруу бодсоноос шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2019 онд 508,3 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5949849,3 мянган төгрөг болж 363238,4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 160,0 мянган төгрөгийн бичилт нь Засаг даргын тамгын газрын он дамжин үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй өглөгийг Засаг даргын Тамгын тушаалаар залруулсан байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Гурванбулаг сум нь тайлант онд 119528,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 108925,2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 91 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого  
төгрөг/

/мянган

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хувь хүний орлогын албан татвар	2000000	3103002,50	1103002,50	155%
Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого	35000000	40862478,60	5862478,60	117%
Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	51279000	41274210,40	10004789,60	80%
Галт зэвсгийн албан татвар	3390000	3554700	164700	105%
Ус, рашаан ашигласны төлбөр	35000	94500	59500	270%
Улсын тэмдэгтийн хураамж	2360000	1767300	592700	75%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	600000	800000	200000	133%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12924000	2931000	9993000	23%
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2000000	2875500	875500	144%

Нэр заагдаагүй орлого	1500000	7227800	5727800	481%
Хүү торгуулийн орлого	8440000	4434745	4005255	52.5%
<b>Нийт дүн</b>	119528000	108925236.50	10602763.50	91%

Орон нутгийн орлого 10602,7 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнд:

1.Хог хаягдлын үйлчилгээний хураамж 9993.0 мянган төгрөгөөр тасарсан нь хог ачих, хог хаягдлын үйлчилгээг иргэд тогтмол үзүүлж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

2. Улсын тэмдэгтийн хураамж 592.7 мянган төгрөгөөр тасарсан нь тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдийн сунгалт хийнэ гэж тооцоолсноос шалтгаалсан байна.

3. Шууд бус орлого 10004.7 мянган төгрөгөөр тасарсан нь малчдад олгох ноос, арьс ширний урамшуулал тооцоолсноос багаар орж ирсэн байна.

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 2470271,7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2392949,6 мянган төгрөгийг урсгал зардалд, 77322,1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 2470271,7 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2435771,7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32500,0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 2000,0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 8 төсөл, арга хэмжээнд 77322,1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 52091,8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2173388821.16 мянган төгрөг буюу 87.9 хувьтай байгаа нь 2019 онд сум хөгжүүлэх сангаас иргэдэд зээл олголт хийгдээгүй, мөн албан томилолтын зардал, төсвийн байгууллагуудын цалин, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд хэмнэгдсэнтэй холбоотой байна. Мөн сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас 32.5 сая төгрөгийн санхүүжилт ирэхээс 4.9 сая төгрөгийн санхүүжилтээ огт авч чадаагүй байна. Санхүүжилтээ бүрэн авч чадаагүйтэй холбоотой холбогдох зардлуудаа бүрэн санхүүжүүлж чадаагүй байна.

**Нэмэлт төсөв:** Засгийн газрын нөөц сангаас Засаг даргын тамгын газарт 32132.5 мянган төгрөг, Ерөнхий боловсролын сургуульд 200.0 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 3000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас Засаг даргын тамгын газарт 74202.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвд 278.5 мянган төгрөг, нийт 109813.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн орлогыг 100% зарцуулсан байна.

## 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 4 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 10602.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 10602.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 9993.0 мянган төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллага хүргүүллээ.

Аудитаар илэрсэн 10602.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Гурванбулаг сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 48789.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 7393.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 37036.5 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байхаар 4358.9 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

## **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийт 154 мэдээлэхээс 154 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн аудитаар 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

## **2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Гурванбулаг сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Гурванбулаг сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### *3.1 Орлогын данстай холбоотой асуудал*

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт хангалтгүй байна. Төлөвлөгөөний биелэлт хангаагүй орлогын нэр төрлөөр авч үзвэл шууд бус орлого 10004,7 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 592.7, хог хаягдлын үйлчилгээний хураамж 9993.0, хүү торгуулийн орлогын орлого 4005.2, мянган төгрөгөөр тус тус тасалнаас болсон байна. Хадгаламжийн хүүгийн орлого 5862.4 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 1103.0 мянган төгрөг, бууны албан татварын орлого 164.7 мянган төгрөг, ТТАМНА төлбөрийн орлого 200.0 мянган төгрөг, Ус, рашаан нөөц ашигласны төлбөрийн орлого 59.5 мянган төгрөг, нэр заагдаагүй орлого 5727.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 875.5 мянган төгрөгөөр тус тус давсан байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Төлөвлөөгүй орлого орсноор зориулалт бус зардал гарах, төсвийн орлого тасарснаас эх үүсвэр дутагдах, хууль журам зөрчигдөх,

#### **3.1.3 3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, жил бүрийн орлогын биелэлтэд дүн шинжилгээ хийж орлогыг бүрэн төлөвлөх, тасарсан орлого биелэх боломж байгаа эсэх талаар судалгаа хийж байх.

### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.**

### 3.2. Төсвийн шууд захирагчтай холбоотой асуудал

#### **3.2.1 Илрүүлэлт:**

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 48789.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 7393.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 37036.5 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байхаар 4358.9 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

Хууль журам, зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн шууд захирагч, санхүү, бүртгэлийн ажилтны сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

#### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй**

Төсвийн төвлөрүүлэн захирагч зөвшөөрсөн Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

ГЭРЭЭТ АУДИТОР

П.ЭРДЭНЭЗУЛ

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>603.788.300,00</u></b>	<b><u>687.516.000,00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	69.593.600,00	157.605.200,00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	69.593.600,00	157.605.200,00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	69.593.600,00	157.605.200,00
31211	Төрийн сангийн харилцах	69.593.600,00	157.605.200,00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	224.256.100,00	152.027.300,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	224.256.100,00	152.027.300,00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>309.938.611,51</b>	<b>377.883.446,29</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>140.192.864,90</b>	<b>154.996.066,00</b>
35110	Тусгай зориулалттай материал	136.311.446,90	142.773.446,90
35130	Эм боох материал	3.881.418,00	12.222.619,10
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1.970.060,00	3.258.320,00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>149.572.686,61</b>	<b>201.783.060,29</b>
35410	Бичиг хэргийн материал	686.800,00	1.786.690,00
35420	Аж ахуйн материал	61.739.312,77	88.953.592,77
35430	Сэлбэг хэрэгсэл	781.500,00	1.197.500,00
35440	Түлш, шатах тослох материал	19.946.666,32	42.196.228,00
35450	Барилгын засварын материал	1.842.200,00	1.553.400,00
35460	Хүнсний материал	10.624.802,90	11.743.244,90
35470	Бусад хангамжийн материал	53.951.404,62	54.352.404,62
35600	Мал амьтад	18.203.000,00	17.846.000,00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4.986.948.115,55</b>	<b>5.262.841.670,85</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4.986.948.115,55</b>	<b>5.262.841.670,85</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>4.906.370.115,55</b>	<b>5.160.179.670,85</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5.046.668.457,06	7.634.968.457,06
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2.825.296.542,44	-2.958.797.658,74
39203	Авто-тээврийн хэрэгсэл	245.534.434,00	289.834.434,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-124.954.296,56	-138.175.035,70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	391.518.220,90	449.873.233,90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-236.802.388,11	-275.813.005,96
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	243.545.985,33	252.698.823,73
39208	Хуримтлагдсан элэгдэл	-146.562.506,34	-160.502.229,15
39209	Зам, гүүрийн байгууламж	22.084.000,00	

Гурванбулаг сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15.280.466,60	15.280.466,60
39216	Дуусаагүй барилга, байгууламж	2.225.300.000,00	
39217	Ном	50.054.285,11	50.812.185,11
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>80.578.000,00</b>	<b>102.662.000,00</b>
39301	Програм хангамж		1.000.000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	80.578.000,00	101.662.000,00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5.590.736.429,85</b>	<b>5.950.357.654,36</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4.285.601,07</b>	<b>508.347,50</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4.285.601,07</b>	<b>508.347,50</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>4.285.601,07</b>	<b>508.347,50</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		508.347,50
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4.243.742,00	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>41.859,07</b>	
41361	Байгууллагад төлөх өглөг	41.859,07	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5.586.450.828,78</b>	<b>5.949.849.306,86</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5.586.450.828,78</b>	<b>5.949.849.306,86</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2.250.276.479,16	2.250.276.479,16
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1.697.337.107,11</b>	<b>2.060.735.585,19</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1.923.078.973,86	1.697.497.107,11
